



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 08 сарын 18 өдөр

Дугаар A/548

Булган сум

“Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивалд оролцох уран бүтээлчдэд дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV Хуралдааны аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай” IV/25 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2025 оны “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардал батлах тухай” A/360 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Соёлын бүтээлч үйлдвэрлэл, соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, нүүдлийн соёлын хамтын ажиллагааны хүрээнд Улаанбаатар хотод 2025 оны 08 дугаар сарын 22-24-ний өдрүүдэд зохион байгуулагдах “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивалд оролцох соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчид, уран бүтээлчдийн байр, замын зардалд 10,000,000 (арван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг хавсралтаар баталж, аймгийн Засаг даргын хөтөлбөр, төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний Соёлын сэргэлт хөтөлбөрөөс 3,000,000 (гурван сая) Байгаль хамгаалах сангаас 7,000,000 (долоон сая) төгрөгийг санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



